

ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАРИМ АСУУДАЛ

А.Гантуул.

Удирдлагын академийн Аюулгүй байдлын
удирдлага, стратегийн профессорын
багийн дэд профессор, цагдаагийн дэд
хурандаа

Товч агуулга: Манай улсын шийдвэр гаргах, бодлого тодорхойлох түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо харьцангуй хязгаарлагдмал байсаар байна. Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангаж эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь улс төр, нийгмийн бүхий л салбарт эерэг үр нөлөө үзүүлдэг.

Түлхүүр үгс: Жендэр, тэгш байдал, шийдвэр гаргах түвшин, эмэгтэйчүүдийн оролцоо, ялгаатай байдал.

Оршил. Жендэрийн тэгш байдал нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хүйсийн хувьд ялгаатай гэж биологийн талаас нь тодорхойлох төдий ойлголт бус харин тэдний боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, эрх чөлөө, эдийн засгийн баталгаа зэрэг нийгэмд эзлэх байр суурь, манлайлал, мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн нөхцөл байдал зэргийг тодорхойлох тухай өргөн хүрээтэй ойлголт юм.

Энэ ч утгаар нь “Жендэр гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг хэлнэ” хэмээн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд тодорхойлжээ.

Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг сонгодог утгаар нь хөгжүүлэхийг хүн төрөлхтөн хүсч, тэмүүлэхийн хирээр нийгмийн олон талт харилцаа бий болж, түүнийг бодлогын түвшинд шийдвэрлэх, зохицуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Нөгөө талаас нас, хүйс, үндэс угсаа, нийгмийн гарал үүсэл зэргээс үл хамааран иргэн бүр нийгмийн харилцаанд тэгш эрхтэй оролцох

нь ардчилсан нийгмийн мөн чанар болдог бөгөөд ардчилсан нийгмийн үнэт зүйлийн нэг нь иргэд шийдвэр гаргалтад эрх тэгш оролцож чадаж байгаа эсэх тухай асуудал байдаг. Өнөөдөр цөөн хэдэн шашны үзэл суртал ноёрхсон улсыг эс тооцвол дэлхий дахинд эмэгтэйчүүд сонгох эрхээ эдлэх бүрэн боломжтой болсон. Өөрөөр хэлбэл дэлхийн ихэнх улс орнуудын сонгуулийн ирцэд хүйсийн ялгаатай байдал тод ажиглагддаггүй бөгөөд харин эмэгтэйчүүдийн сонгогдох эрхийн асуудал судлаачдын анхаарлыг татсаар байна.

Тиймээс шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн асуудал яагаад чухал вэ?; эмэгтэйчүүд яагаад улс төр, нийгмийн харилцаанд манлайлан оролцох ёстой вэ?; тэдний оролцоо нэмэгдснээр нийгэмд ямар эерэг үр нөлөө гарч болох вэ?; манай улсын эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш хэрхэн хангагдаж байна вэ?; эмэгтэйчүүдийн оролцоог шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлэхэд ямар хүчин зүйлүүд сөргөөр нөлөөлж байна вэ? зэрэг асуултыг тавьж, хариулт олохыг хичээлээ.

Нэг. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн асуудал. Эмэгтэйчүүдийг сонгож, шийдвэр гаргах түвшинд ажиллууллаа гээд тэд нийтийн сайн сайхны төлөө юу хийж чадах юм, тэдний хүч хүрэхгүй гэсэн хэвшмэл ойлголт бидний дунд амь бөхтэй оршдог бөгөөд үүнийг зориудаар дэвэргэн нийгэмд уг буруу ойлголтыг бататгах гэсэн хандлага ч ажиглагдаж байна.

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь улс төрийн соёлыг төлөвшүүлэх, нийгмийн олон талт харилцааг зохицуулахад эерэг үр нөлөө үзүүлдэгийг эрдэмтэн, судлаачдын олон судалгаа нотолдог. Тухайлбал:

1.1. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэхэд төрийн хүлээн зөвшөөрөгдөх /легитим/ чанар сайжирдаг:

Хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл нэмэгдэх тусам иргэдийн, тэр дундаа эмэгтэйчүүдийн төрд итгэх итгэл, төрийг хүлээн зөвшөөрөх байдал нэмэгддэг болохыг АНУ-ын судлаачид мужуудын иргэдийн төлөөлөгчдийн танхимуудыг харьцуулан судалж, судалгааны үр дүнгээр тогтоосон байдаг. Тэд

судалгааны тайландаа: а/ төлөөлөгчдийн танхим дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь өсөх тусам тухайн мужийн эмэгтэйчүүд “Төр энгийн иргэдэд нээлттэй ажилладаг,” “Над шиг хүмүүсийн үзэл бодлыг төр сонсдог,” “Миний асуудалд төр анхаарал хандуулдаг” гэж судалгаанд хариулж байсан тухай дурьдсан байдаг; б/ эсрэгээрээ шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн эзлэх хувь буурах тусам засаг захиргаагаа сөргөөр үнэлж байсан байна.¹

Эндээс улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх нь төрийн легитим чанарыг сайжруулах сайн үр нөлөөтэй байна гэсэн дүгнэлтийг хийж болно.

1.2. Эмэгтэйчүүд улс төрд эерэг соёлыг төлөвшүүлэх нэг хүчин зүйл нь болдог:

Зарим судлаачид эмэгтэйчүүдийн оролцоо шийдвэр гаргах түвшинд нэмэгдснээр улс төрийн уламжлалт хэв маягийг өөрчлөн харилцан биедээ нээлттэй, талуудын оролцоог хангасан хамтын шийдвэр гаргах соёлыг бий болгодог. Эмэгтэйчүүд улс төрийн шийдвэр гаргах түвшинд идэвхтэй оролцсоноор нийгэмд үзүүлэх хамгийн чухал эерэг нөлөөллийн нэг нь бусад эмэгтэйчүүдийн бахархал, хүндэтгэн дууриах дүр төрхийг бий болгож, эмэгтэйчүүдийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэхэд манлайлал үзүүлдэг байна.

1.3. Эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэх тусам авилгын түвшин буурдаг:

Хэдийгээр энэ нь батлагдаагүй маргаантай сэдэв хэдий ч Дэлхийн банкны олон улсын харьцуулсан судалгаанаас харахад хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн тоо нэмэгдэх тусам улс орнуудын авилгын түвшин буурч байгаа ерөнхий дүр зураг ажиглагдсан байна. Гэхдээ энэхүү үзэгдэл нь тохиолдол уу эсвэл үнэхээр эмэгтэйчүүд авилгыг бууруулдаг уу гэдэг нь одоогоор нотлогдоогүй гэдгийг тодотгох нь зүйтэй.

Ямартай ч шийдвэр гаргах түвшинд ажилладаг эмэгтэйчүүдийг ижил түвшний эрэгтэйчүүдтэй харьцуулахад тэд илүү итгэл даах чадвартай, шударга, ёс зүйн категорийг баримтлахыг хичээдэг, нийтийн эрх ашигийг чухалчилж шийдвэр

¹ С.Болдсайхан. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, УБ, 2020

гаргах хандлагатай байдаг гэдгийг судалгааны олон дүгнэлтэд дурьдсан байдаг.

Тийм ч учраас нийгэмд тулгамдаж байгаа олон асуудлыг цогцоор нь шийдвэрлэхэд эмэгтэйчүүдийн төлөөллийг шийдвэр гаргах түвшинд зайлшгүй хангах ёстой гэдэг жендерийн суурь үзэл баримтлалтай ихэнх судлаачид санал нийлдэг. Тодруулбал, эмэгтэйчүүдийн оролцоо шийдвэр гаргах түвшинд нэмэгдснээр нийгмийн бүхий л бүлгүүдийн /гэр бүл, хүүхэд, залуус, эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эрэгтэй, эмэгтэй бүлэг хүмүүс гэх мэт/ эрх ашгийг хангах, хамгаалахад төрийн бодлого чиглэгдэж, бодлого тогтвортой байж чанарын дэвшил гарах боломжтой.

Монгол Улсын нийт насанд хүрсэн иргэдийн 51.7 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг.¹

Хүн амын талаас илүүг бүрдүүлж байгаа эмэгтэйчүүдийн төлөөлөл хууль тогтоох, шийдвэр гаргах түвшинд хэрхэн хангагдаж байгааг авч үзвэл:

2016 оноос өмнөх Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнгээр эмэгтэйчүүдийн төлөөлөл хууль тогтоох байгууллагад 10 хүрэхгүй тоогоор сонгогдож байсан статистик бүхий л төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудын судалгаанд дурьдагджээ. Харин 2016 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нийт 174 эмэгтэй нэр дэвшигч оролцож 11; 2020 оны ээлжит сонгуульд оролцсон 129 эмэгтэй нэр дэвшигчээс 13 эмэгтэй Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон байна.

Энэ нь Монгол Улсын Их Хурал дахь нийт төлөөллийн 17,3 хувь бөгөөд уг үзүүлэлтээр манай улс дэлхийн 189 улсаас 122-д^{1 2} бичигдсэн байна.

Хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг дэлхийн дундаж үзүүлэлтээр авч үзэхэд 24,9 хувь бөгөөд энэ үзүүлэлттэй харьцуулахад манай улс дэлхийн дундажаас 7,6 хувиар бага байгаа юм. Эмэгтэйчүүд урьд урьдаас илүү олноор хууль тогтоох байгууллагад сонгогдож ажилласнаар олон жил хүлээгдсэн Тэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль”, “Хүүхэд харах

¹ Монгол Улсын Статистикийн хорооны тайлан, УБ, 2020 он.

² С.Болдсайхан. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, УБ, 2020 он.

үйлчилгээний тухай хууль”, “Хамтын тэтгэврийн сангийн тухай хууль”, “Хүүхдийн эрхийн тухай хууль”, Тэр бүлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга зэрэг нийгмийн шинж чанартай олон хууль батлагдсан билээ. Цаашид эмэгтэйчүүд илүү олноороо Улсын Их Хуралд сонгогдвол үүнээс ч илүү эерэг үр дүн гарах боломжтой юм.

Жендэрийн тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хуульд “Яам, агентлаг болон орон нутгийн удирдлагын байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөлөл бүх түвшинд 15-40 хүртэл хувиас доошгүй байх”-аар хуульчилсан байдаг.

Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн 27,1 хувь нь эмэгтэйчүүд байна. НҮБХХ-ийн 2020 оны “Хүний хөгжлийн илтгэл”-д дурьдсанаар Монгол Улс жендэрийн тэгш бус байдлаар бүсийн болон дэлхийн дундажаас доогуур үзүүлэлттэй байна.

Өнгөрсөн хугацаанд удирдлагын шийдвэр гаргах түвшинд ажиллаж байсан бүрэлдэхүүнийг хэлбэрийн хувьд авч үзвэл нийгмийн дундажаас дээш давхаргын, 50 гаруй насны, эрэгтэйчүүд зонхилж¹ байсан судалгаа байдаг. Энэ бүлэг хүмүүс нь нийгмийн харилцааг бүхэлд нь зохицуулсан, бусад бүлэгт ээлтэй, мэдрэмжтэй шийдвэр гаргах нь эргэлзээтэй.

Харин 2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр шийдвэр гаргах түвшний бүрэлдэхүүний нас, хүйсийн ангилалд тодорхой ахиц гарч, төрийн бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх шатанд дундаж нас залуужсан байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилохдоо 23,5 хувь буюу 4 салбарыг эмэгтэйчүүдээр удирдуулж, 2 эмэгтэй Дэд сайдыг Засгийн газрын бүрэлдэхүүнд томилон ажиллуулж байна.

Түүнчлэн төрийн захиргааны удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг авч үзвэл: Яамдын Төрийн нарийн бичгийн түвшинд 7,7 хувь, агентлагийн даргын түвшинд 3,3 хувь, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын түвшинд 18,2 хувь байгаа бол Аймаг, нийслэлийн Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын түвшинд ажиллаж байгаа

¹ А.Гантуул. Хууль сахиулах салбарын шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш байдлыг хангах асуудал, Хууль сахиулахуйн удирдлага сэтгүүл №4, 2018

эмэгтэй байхгүй байна.¹ Эндээс бид албан тушаалын зэрэг дээшлэх тусам эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ багасч байгааг харж болно.

Үүний зэрэгцээ манай улсын түүхэнд нэг ч эмэгтэй Аймаг, нийслэлийн засаг дарга болон Ерөнхийлөгч, Улсын их хурлын дарга, Ерөнхий сайдаар ажиллаж байгаагүй нь улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо тун хангалтгүй байгааг баталж байгаа юм.

Хоёр. Шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш байдлыг хангах зарим асуудал. Хүмүүнлэг, иргэний ардчилсан Монгол Улсыг бид байгуулж, 1992 оны Үндсэн хуульд “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй” хэмээн тунхагласнаас хойш өдгөө 30-аад жилийн нүүрийг үзжээ. Өнгөрсөн хугацаанд эмэгтэйчүүдийн нийгэм, улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоо бага багаар нэмэгдэж байгаа нь дээр дурьдсан судалгаануудаас харагдаж байгаа нь сайшаалтай хэдий ч шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн манлайллыг улам илүү нэмэгдүүлэх, тэднийг чадавхижуулах зайлшгүй шаардлага бий болсонтой маргахгүй бизээ.

Өнөөдөр Монгол Улс хүний хөгжлийн үзүүлэлтээр дэлхийн 177 орноос 92, эдийн засгийн өрсөлдөх чадварын индексээр дэлхийн 140 орноос 99, бизнесийн орчны индексээр дэлхийн 190 орноос 74, авлигын индексээр 93 дугаар²-т тус тус жагсаж байна. Монгол Улс энэ мэт улс орнуудын хөгжлийн түвшинг тодохойлох олон шалгуур үзүүлэлтээр бүс нутгийн улс орнууд, дэлхийн дунджаас доогуур байдалтай үзүүлэлттэй байсаар байна. Өнгөрсөн хугацаанд хуримтлагдсан нийгэм, эдийн засгийн болоод салбар бүрт тулгарч буй олон арван асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэхэд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн аль алиных нь идэвх, оролцоо нэн чухал юм.

Иймээс өөрийн ажиллаж буй хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий салбарын, цагдаа, хил, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, шүүхийн шинжилгээний болон онцгой

¹ Төрийн албаны зөвлөл

² Алсын хараа-2050 бодлогын баримт бичгийг боловсруулах Ажлын хэсгийн судалгааны тайлан, УБ, 2020.

байдлын асуудал эрхэлсэн байгууллагуудын удирдах бүрэлдэхүүнд ажиллаж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь, шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал хэрхэн хангагдаж байгаа талаар шинжилгээ хийж үзлээ.

Бие бүрэлдэхүүн	Үзүүлэлт		
	Нийт бүрэлдэхүүнээс эмэгтэйчүүдийн эзлэх хэмжээ (хувиар)	Шийдвэр гаргах түвшинд буюу дарга, захирлын зөвлөлийн гишүүнээр ажилладаг байдал (тоогоор)	Газар, алба, хэлтсийн дарга болон түүнтэй адилтгах албан тушаалд ажиллаж байгаа байдал (тоогоор)
Цагдаа, дотоодын цэргийн бүрэлдэхүүн	14,1 хувь	0	2
Хил хамгаалах албаны бүрэлдэхүүн	31 хувь	0	22
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны бүрэлдэхүүн	34,1 хувь	2	6
Онцгой байдлын албаны бүрэлдэхүүн	13 хувь	0	5
Шүүхийн шинжилгээний албаны бүрэлдэхүүн	39,4 хувь	2	4
Дотоод хэргийн их сургуулийн бүрэлдэхүүн	43 хувь	1	12 хувь

Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллага, ажил үүргийн онцлог байх нь зүй ёсны асуудал боловч дээрх статистикаас үзэхэд хууль сахиулах салбарын шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш байдлыг хангах асуудал хангалтгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Түүнчлэн салбарын удирдах бүрэлдэхүүнийг бэлтгэж байгаа Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын Академийг төгсөгчдийн болон одоо суралцаж байгаа суралцагчдын статистикийг авч үзэхэд удирдах бүрэлдэхүүний нөөцөөр бэлтгэгдэж байгаа эмэгтэйчүүдийн тоо маш хангалтгүй байна. Тодруулбал: Өнгөрсөн хугацаанд нийт

хууль сахиулах салбарын 194 албан хаагч тус Академид суралцаж төгссөнөөс 6 эмэгтэй албан хаагч амжилттай суралцаж “Онцсайн” үнэлгээтэй төгсчээ. Харин одоо суралцаж байгаа 81 суралцагчаас 8 эмэгтэй суралцагч байна. Дээрх статистикийг нэгтгэн дүгнэвэл нийт суралцагч, төгсөгчдийн ердөө 5,1 хувь нь эмэгтэйчүүд байгаа юм.

Дээрх судалгаануудад үндэслэж: Эмэгтэйчүүдийн оролцоог шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлэхэд ямар хүчин зүйлүүд сөргөөр нөлөөлж байна вэ? гэсэн асуулт тавигдаж болох юм.

Улс төр сонирхдог, улс төрийн талаар цэгцтэй мэдлэгтэй хүмүүс улс төрд илүү идэвхтэй оролцдог бөгөөд дэлхий дахинд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү улс төр сонирхдог, улс төрийн талаар илүү мэдлэгтэй байдаг нь олон судалгаагаар тогтоогджээ. Үүнийг баталж болох нэг жишээг дурьдахад Монгол Улсад хийсэн 2020 оны сонгуулийн дараах судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 24 хувь нь улс төр сонирхдог гэж хариулсан байхад эрэгтэйчүүдийн 42 хувь нь дээрхтэй ижил хариулт өгсөн байна¹.

Түүнчлэн эмэгтэйчүүд улс төрд оролцох хүсэл эрмэлзэл багатай байдаг байна. Учир нь эмэгтэйчүүдийн дунд улс төрийн өндөр албан тушаал, шийдвэр гаргах түвшинд ажиллахад өөрийгөө тэнцэхгүй гэж дутуу үнэлэх хандлага давамгайлж ажиглагддаг. Ажил мэргэжил, туршлага, ур чадварын түвшингөөр эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг харьцуулан судалж үзэхэд өөрийгөө сонгуульд өрсөлдөх хэмжээний ур чадвар, улс төрийн туршлагатай гэж эрэгтэйчүүд илүү үнэлж дүгнэдэг байна. Гэтэл бодит байдалд ихэвчлэн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү ур чадвар, туршлагатай байдаг гэж АНУ-ын зарим судлаачид тэмдэглэжээ. Түүнчлэн судалгаанд оролцсон эмэгтэйчүүд шаардлагатай нөөц, цаг зав хомс байдаг гэдгээ тодотгосон байдаг. 2020 онд Монгол Улсад хийсэн судалгаанд оролцогчдоос сонгуульт албан тушаалд өрсөлдөж буй эмэгтэйчүүдийн хувь бага байгаа талаар асуухад тэдний 75 хувь нь “эмэгтэйчүүдэд ар гэрийн ажил, хүүхдээ асрах нь илүү чухал байдаг” гэж хариулсан байна^{1 2}.

Нөгөөтэйгүүр улс төр, шийдвэр гаргах түвшний орон зай бол зөвхөн эрчүүдийнх гэж өмчлөх уламжлалт хандлага олон улсад,

¹С.Болдсайхан. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, УБ, 2020 он.

² Мөн тэнд

ялангуяа хөгжингүй, ядуу буурай улсуудад хүчтэй хадгалагдсаар байна. Тиймээс эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоонд саад болж буй үндсэн суурь шалтгаан нь жендерийн уламжлалт хэвшсэн ойлголт гэдэгтэй ихэнх судлаачид санал нийлдэг. Түүнчлэн ихэнх хүмүүс улс төрийн манлайллыг шийдэмгий, өөртөө итгэлтэй байдал, бусдыг захирах чадвараар төсөөлдөг бөгөөд ийм шинж чанартай эрэгтэй улс төрч, удирдах албан тушаалтныг нийгэм эерэгээр хүлээж авдаг хирнээ эмэгтэйчүүдийг харин сөргөөр хүлээж авах хандлагатай байдаг. Олон улсад хийгдсэн санал бодлын тандалт судалгаануудаас харахад жендерийн уламжлалт ойлголт улс бүрт харилцан адилгүй байна. “Asian Barometer Survey”-д оролцсон Монголчуудын 34 хувь нь “Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй ижил түвшинд улс төрд оролцох хэрэггүй” гэдэг өгүүлбэртэй “Санал нийлж байна” эсвэл “Санал маш их нийлж байна” гэж хариулсан байна. Энэ нь манай улсад жендерийн уламжлалт ойлголт бөх бат оршсоор байгааг харуулж байна.

Дүгнэлт

Жендэрийн тэгш байдлыг хангаснаар нийгэм илүү хүмүүнлэг, ёс зүйтэй, бүтээлч болдог гэж судлаачид үздэг бөгөөд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг тэгш оролцуулснаар төрийн бодлого тодорхойлоход иргэд, олон нийтийн оролцоо илүү сайн хангагдаж, нийгмийн олон бүлгийн сонирхлыг бодлогын түвшинд шийдвэрлэх боломж бүрддэг. Тиймээс жендэрийн тэгш байдлыг хангаж боловсруулсан бодлого илүү тогтвортой, үр дүнтэй, амьдралд нийцтэй байдаг гэж дэлхийн хүний хөгжлийн талаарх олон судалгааны тайланд дурьдсан нь бий.

Нийгмийн хандлага болон хууль сахиулах салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйтэйчүүдэд олон нийт, салбарын бүрэлдэхүүний зүгээс давхар шаардлага, шүүлтийг тулгах нь олонтаа ажиглагддаг. Тодруулбал зөвхөн эмэгтэй хүн учраас нийгмийн халамж, хамгааллын асуудлуудад илүү төвлөрч ажиллах ёстой, цаашлаад шийдвэр гаргагч, удирдах албан тушаалтан гэдгээр нь харах бус харин гадаад төрх, гэр бүлийн амьдрал зэрэг хувь хүний холбогдолтой асуудлуудыг нь чухалчлан үзэх нь түгээмэл байна.

Хэдийгээр Монгол Улсад эмэгтэйчүүд удирдах албан тушаал хаших, сонгох, сонгогдох эрх нээлттэй боловч аль ч салбарт тэр дундаа хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг салбарт тодорхой байр суурьтай, шийдвэр гаргах түвшинд ажиллах боломж хязгаарлагдмал байна. Энэ нь ч дээрх статистик судалгаануудаас харагдаж байгаа юм.

Санал. Эмэгтэйчүүд нийгэмд болон салбартаа дуу хоолойгоо хүргэж тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх, баялаг бүтээх, улсынхаа хөгжил дэвшилд гар бие оролцохын тулд өөрсдийгөө чадваржуулах, бусаддаа манлайлах, асуудлаа олж харж эвлэлдэн нэгдэх нь нэн чухал байна.

Хууль сахиулах салбарын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтнууд удирдлагын хэвшмэл загвараас салж, оролцоонд тулгуурласан, эрх мэдлийг хуваарилсан удирдлагыг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүний тулд Хууль сахиулах салбарын агентлаг, байгууллагуудын даргын болон захирлын зөвлөлд тодорхой тооны квотоор эмэгтэй албан хаагчийг зөвлөх эрхтэйгээр гишүүнээр ажиллуулах зэргээр албан хаагчдын нийтлэг эрх ашгийг хамгаалах, жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн салбарын бодлогыг баримталж ажиллах нь зүйтэй юм.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Алсын хараа-2050 бодлогын баримт бичгийг боловсруулах Ажлын хэсгийн судалгааны тайлан, УБ, 2020.

Монгол Улсын Статистикийн хорооны тайлан, УБ, 2020.

Болдсайхан.С, Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, УБ, 2020

Гантуул.А. Хууль сахиулах салбарын шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш байдлыг хангах асуудал, Хууль сахиулахуйн удирдлага сэтгүүл №4, 2018.